

Товч мэдээ, ажиглалт

**Номхон Далайн Баруун болон Зүүн Өмнөд Азийн бүсийн Томуугийн Үндэсний Төвүүдийн уулзалтын тухай**

Томуугийн Үндэсний Төвүүдийн ээлжит Зөвлөлдөх уулзалт 2011 оны 6 дугаар сарын 7-10-ны өдрүүдэд Лаос улсын Вьентьян хотод зохион байгуулагдлаа.

Уулзалтанд ДЭМБ-ын Женев дэхь Төв, ДЭМБ-ын Австрали, Япон, БНХАУ-ын Хамтын Ажиллагааны Төв, АНУ-ын ӨХСТ, Номхон Далайн Баруун болон Зүүн Өмнөд Азийн бүс, 2 бүсийн 20 гаруй орны Томуугийн Үндэсний Төвүүдийн төлөөлөгчид оролцож, 3 өдрийн турш томуугийн тандалтын асуудлаархи дэлхийн, бүсийн, улс орнуудын ололт, амжилт, тулгамдаж буй асуудлыг ярилцан, харилцан туршлага солилцож, уулзалтын 4 дэхь өдөр томуугийн чиглэлээр цаашид хийх эрдэм шинжилгээ, судалгааны ажлын талаар ярилцлага зохион байгууллаа. Манай Томуугийн Үндэсний Төвийг төлөөлж ЭМЯ-ны Нийгмийн Эрүүл Мэндийн Бодлогын Хэрэгжилтийг Зохицуулах Газрын мэргэжилтэн П. Оюунцэцэг, ХӨСҮТ-ийн Ерөнхий Захирал Д. Нямхүү, НЭМХ-ийн мэргэжилтэн Б. Ичинхорлоо, ХӨСҮТ-ийн ЭСХАХН-ийн дарга, томуугийн төслийн томуугийн тандалт хариуцсан их эмч А. Бурмаа нар оролцож, “Монгол улс дахь томуугийн тандалтын тогтолцоо, сүүлийн 5 жилийн ТТӨ-ий өвчлөлийн байдал” сэдэвт ханын илтгэл, “Томуугийн интернетэд суурилсан мэдээллийн тогтолцоо” сэдэвт аман илтгэл тавьж оролцон, ДЭМБ-ын Монгол дахь Суурин Төлөөлөгчийн газрын Халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн Луо Дапенг нарийн бичгийн бүрэлдэхүүнд орж ажиллаа. Зөвлөлдөх уулзалтын хөтөлбөр, тавигдсан илтгэлүүд, ДЭМБ-ын Номхон Далайн Баруун болон Зүүн-Өмнөд Азийн бүсээс томуугийн үндэсний тандалтыг цаашид бэхжүүлэх тухай төлөвлөгөөний төслийн дэлгэрэнгүйг [http://www.flu.mn/mgl/index.php?option=com\\_content&task=view&id=727&Itemid=51](http://www.flu.mn/mgl/index.php?option=com_content&task=view&id=727&Itemid=51) хавтас дотор нүүрнээс үзнэ үү [Зураг 2].

**А.Бурмаа  
ХӨСҮТ**

\* \* \*

**“Алтан гагнуур”**

2011 оны 5 дугаар сарын 26-нд ЭМШУИС дээр төгсөгчдийн “Алтан гагнуур-2011” ээлжит чуулга уулзалт боллоо. Энэ удаагийн чуулга уулзалтанд МУИС-ийн хүн эмнэлгийн факультетийг 1951, 1961 онд, АУДэС-ийг 1971, 1981 онд, АУИС-ийг 1991, 2001 онд төгсөгчид болон ЭМШУИС-ийг 2011 онд төгсч байгаа оюутнуудыг төлөөлсөн 500 гаруй эмч, эрүүл ахуйч, эм зүйч, багш, эрдэмтэд цугларч, “Өрлөг эх”(Alma mater)-дээ талархал илэрхийлж, олон жил уулзалдаагүй нөхөдтэйгээ уулзан учирч, чин сэтгэлийн халуун яриа өрнүүллээ. 1951 оны төгсөгч, ахмад эмч Б.Буниа, 1961 оны төгсөгч, “Монгол улсын эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан”, профессор Г.Дашзэвэг, 1961 оны төгсөгч, ЭМШУИС-д 50-дахь жилээ багшлаж буй, “Монгол улсын гавьяат багш” Т.Зэвгээ, 1961 оны төгсөгч, Дундговь аймагт сумын эмчээр 50-дахь жилээ ажиллаж байгаа, “Монгол улсын хүний гавьяат эмч” Х.Чимэд нарын 35 төгсөгч ЭМШУИС-ийн захирлын тушаалаар шилдэг эмч, эрүүл ахуйч, эм зүйч, багш, эрдэмтэн, зохион байгуулагч “Өргөмжлөл” авлаа.

Монгол-АНУ-ын хамтарсан “Томуугийн харуудан тандалтыг бэхжүүлэн хөгжүүлэх” төслийн захирал, МАУА-ийн ерөнхийлөгч, “Монгол улсын эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан”, академич П.Нямдаваа багш маань энэ удаагийн 7 үеийн төгсөгчдийн “Шилдгийн шилдэг эмч, багш, эрдэмтэн”-ээр шалгарлаа. Багшдаа баяр хүргэж, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

**А.Энхбаатар  
ТҮТ**

\* \* \*